



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.03.25 № 11

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

Асуулга тавих тухай

Танд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлж, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг хэрхэн тодорхойлж байгаа талаар;

2. Шинжлэх ухааны зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төсөл, технологийн болон туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийн эдийн засгийн үр өгөөж, судалгаа хөгжүүлэлтийн ажлуудын бодит үр дүн, гадаадын нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүллийн тоо хэмжээ, патент авсан бүтээлийн тоо зэрэг үр дүнгийн үзүүлэлтийг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар;

3. Үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд шинжлэх ухаан, инновацийн дэд бүтцийг байгуулах, шинжлэх ухаан, инновацийн кластерийн барилга, шинжлэх ухааны парк байгуулах зэрэг томоохон бүтээн байгуулалтыг өрнүүлэх зорилтуудыг дэвшүүлж ирсэн. Энэ чиглэлээр хийх ажлын төлөвлөлт, гарч байгаа хүндрэл бэрхшээлүүд, хэрхэн шийдвэрлэх талаар салбарын зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаар;

4. Судалгаа хөгжүүлэлтийн ажилд инженерчлэл, технологийн, ялангуяа био технологийн салбарын ажлын эзлэх хувь, хүний нөөц, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн үзүүлэлт, төсвөөс бусад эх үүсвэрийн санхүүжилтын эзлэх хувь зэргийг дээшлүүлэх тал дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлэх зорилт 2024 он гэхэд хэрэгжих боломжтой эсэх талаар;

5. Өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүр нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхэд

2020000132

шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулиудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажлууд, шинжлэх ухаан, дээд боловсрол, аж үйлдвэрлэлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах талаар хэрхэн анхаарч ажиллаж байгаа талаар;


6.Ковидын нөхцөл байдалтай холбогдуулаад эрдэм шинжилгээ, инноваци, технологийн судалгаа хөгжүүлэлтийг эрчимжүүлэхэд ямар дэмжлэг үзүүлэх, инновацийн төсөл хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн хамтын түншлэлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсын зах зээлд гаргах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар;

7. Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх, ялангуяа дунд сургуулийн байгалийн шинжлэлийн хичээлийг чанаржуулах, боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA зэрэг) хамрагдах, хүүхдийн танин мэдэхүй, ажил мэргэжлийн чиглэлийг төлөвшүүлэх тал дээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар 39.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ӨНӨРБОЛОР

2020000132